



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2026.06.12 № 01/2025
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Таны хүүхдийн төлөө сангийн үйл ажиллагааны талаар тавьсан асуулгатай танилцлаа.

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21² дугаар зүйлийн 21^{2.2} дахь хэсэгт заасан эх үүсвэрүүдээс Хүүхдийн төлөө санд 2021 оноос 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл нийт 30,475,012.3 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

2. Мөн хуулийн 21² дугаар зүйлийн 21^{2.3} дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2021 оноос 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл нийт 1,193,207.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3. Хүүхдийн төлөө сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байдал, хууль, журам хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлын тухайд:

Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.4} дэх хэсэгт “Энэ хуулийн 17^{1.3}-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ” гэж заасан. Хуулийн дээрх заалтын дагуу Хүүхдийн төлөө санд нийт 28,358,356.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөн.

Хуулийн дээрх заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21² дугаар зүйлийн 21^{2.2.1} “автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого” гэх заалт хүчинтэй хэвээр байгаа нь холбогдох хуулийн зохицуулалтын хооронд эрх зүйн коллизийн шинжтэй нөхцөл байдлыг үүсгэж байх тул аль зохицуулалтыг давуу хэрэглэж, шийдвэрлэх талаар нэмэлт тайлбар, эсхүл хууль тогтоомжийн уялдааг хангах шаардлагатай байна.

Хавсралтаар тайлбар, дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.



Т. АУБАКИР

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2026 оны 06 дугаар сарын 12 -ны өдрийн
01/2025 дугаар албан бичгийн хавсралт

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ҮЛДЭГДЭЛ:

Хүүхдийн төлөө санд 2021 оноос 2026 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар Автотээврийн үндэсний төвөөс автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого 28,358.4 сая төгрөг, иргэн аж ахуйн нэгжээс өгсөн хандив 39.3 сая төгрөг, нийт 30,475.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн.

Сангаас 2021 оноос 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхэд, оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд нийт 507 хүүхдэд 1,193.2 сая төгрөгийг зарцуулсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжээс 159.0 сая төгрөгийг 2025 онд санд төвлөрүүлсэн. Сангийн үлдэгдэл 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 29,281.8 сая төгрөг байна.

/мянган төгрөгөөр/

№	Он	ОРЛОГО				ЗАРЛАГА					Сангийн үлдэгдэл
		ХАНДИВ ТУСЛАМЖ				Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт		Олон улс, тив, дэлхийн уралдаан, тэмцээн, наадамд ажилттай оролцсон, оролцох болзол хангасан хүүхэд			
		Хүүхдийн төлөө фондын хандив	АТҮТ	Иргэн аж ахуйн нэгж байгууллагын хандив	Нийт орлого	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл		
								Хүүхдийн тоо	Мөнгөн дүн		
1.	2021	2,077,258.5	3,451,300.0	12,055.0	5,540,613.6	-	-	25,000.0	15	25,000.0	5,515,613.6
2.	2022		4,390,076.1	5,000.0	4,395,076.1	-	-	81,800.0	30	81,700.00	9,828,989.7
3.	2023		4,908,728.8	100,000.0	5,008,728.8	-	-	9,273,800.0	152	328,556.5	14,509,159.99
4.	2024		10,091,772.7	342.0	10,092,114.7	-	-	500,000.0	94	260,709.7	24,340,564.99
5.	2025		5,207,061.1	209,420.0	5,416,481.1	7,815,900.0	-	500,000.0	161	336,795.3	29,420,251.1
6.	2026.04.30			22,000.0	22,000.0	14,383,082.6		436,500.0	55	160,446.1	29,281,804.7
7.	Нийт	2,077,313.60	28,358,356.7	39,342.0	30,475,012.3		-	-	507	1,193,207.3	29,281,804.7
				2026 онд бүтээн байгуулалтын төсөл санхүүжүүлэх боломжит төсөв		7,238,682.6					

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2025-2026 ОН ДАМЖИН САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ:

Хүүхдийн төлөө сангийн төсөв 2025 онд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын санхүүжилтэд 7,815.9 сая төгрөг батлагдаж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүүхдийн өвчлөл, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх оношилгоо, эмчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 4,665.4 сая төгрөг, Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын хоолны газрын засвар шинэчлэлд 991.1 сая төгрөг, цогцолборын задгай болон хөл бөмбөгийн талбайн шинэчлэл засварт 1,488.0 сая төгрөг, нийт 7,144.5 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн.

--oOo--